



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ц.БААТАРХҮҮ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жамсгийн Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудал: www.cabinet.gov.mn

2026.09.18 № ХЭГ/3163
танай _____-НЫ № _____-Т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Танаас газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 123 хуудастай.

Хүндэтгэсэн,



Монгол Улсын Засгийн газар
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Баттөмөр Энхбаяр
2026.09.18 10:42



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 02 03, Факс: (976-11) 32 28 83,
Цахим шуудан: info@gazar.gov.mn

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ

2026.09.11 № 1/2592
танай -ныг №

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгээс 2026 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 48 дугаартай албан бичгээр Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын дагуу дараах хариуг хүргүүлж байна.

НЭГ. Иргэнд эзэмшүүлэх газрын мэдээлэл, газар олголтын талаар:

1.1. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан бөгөөд уг өөрчлөлтөөр иргэдийн газартай холбоотой хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх болсон. Хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлт хийж, төрд байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүйгээр 50 гаруй төрлийн цаасан материалыг QR кодоор баталгаажуулан цахимаар бүрдүүлдэг болсон. Энэхүү ажлын үр дүнд албан хаагчийн ажлын ачааллыг 85 хувиар, иргэний цаг хугацаа, зардлыг 90 хувиар тус тус бууруулсан үр дүнтэй байна.

Мөн Газрын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмыг шинэчлэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор баталсан. Улмаар газартай холбоотой 27 төрлийн хүсэлтийг 1-15 хоногт шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд 2026 оны хагас жилийн байдлаар улсын хэмжээнд 380,771 хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн байна.

1.2. Иргэн, хуулийн этгээд нь цахим үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/, газрын цахим систем /www.egazar.gov.mn/ болон киоск машинаар дамжуулан газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой 27 төрлийн хүсэлтийг илгээх, 6 төрлийн гэрчилгээ, 13 төрлийн лавлагааг цахимаар хүлээн авч байгаа бөгөөд өөрийн гаргасан хүсэлтийнхээ явц, шийдвэрлэлтийн байдлыг тогтмол хянаж, гар утсандаа тухай бүр мэдээллийг хүлээн авч байна.

1.3. Газрын дуудлага худалдаа, төсөл шалгаруулалтын хувьд Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ээр зохион байгуулдаг бөгөөд 2025 оны байдлаар 657 нэгж талбарыг дуудлага худалдаагаар, 180 нэгж талбарыг төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулан, улсын төсөвт 37.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.

ХОЁР. Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэнд өмчлүүлэх газрын төлөвлөгөөний талаар:

2.1.Монгол Улсын иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоохдоо Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Хот байгуулалтын тухай хуульд заасан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу тогтоодог.

Нийслэлийн хувьд "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг" хэрэгжиж байгаа хэдий ч төлөвлөлтийн хязгаараас хэтэрсэн газар ашиглалт үүссэн, дэд бүтцийн хангамж хязгаарлагдмал зэргээс шалтгаалан шинэ суурьшлын бүсийн төлөвлөлт, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй байна. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" батлагдсанаар шинэ суурьшлын бүсэд иргэдэд өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээг тодорхойлон шийдвэрлэх боломжтой болох юм.

Харин 21 аймгийн хэмжээнд 2026 онд 25540 иргэнд шинээр 2659.71 га газрыг өмчлүүлэхээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тул эдгээр байршилд нийслэлийн иргэд хүсэлтээ гарган шийдвэрлүүлэх эрх нь нээлттэй хэдий ч орон нутгийн төлөвлөгдсөн газрын нөөц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хүрэлцээ, хангамжаас хамааран харилцан адилгүй шийдвэрлэгдэж байна.

2.2.Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлж, Ашигт малтмал, газрын тосны газартай дундын мэдээллийн сангаар дамжуулан өгөгдөл, мэдээлэл солилцох ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах үйл ажиллагааг Газрын кадастрын мэдээллийн системээр дамжуулан эрхлэх ажлыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтран зохион байгуулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж газрын давхардал үүсэхгүй байх боломжийг бүрдүүлсэн.

Түүнчлэн Зам, тээврийн яам, Ойн газар, Усны газруудын мэдээллийг тогтмол хүлээн авч Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд байршуулан, газар ашиглалтад цахим системээр хяналт тавих боломжийг бүрдүүлснээр хамгаалтын бүсэд газар олгох болон газрын эрхийг давхардуулан олгодог асуудлыг арилгаад байна.

ГУРАВ. Нөхөн олговор, маргаан, хариуцлагын талаар:

3.1.Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас 2026 оны 08 дугаар сард ирүүлсэн мэдээллээс үзэхэд нийслэлийн хэмжээнд 2023-2025 онд Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан авто зам, гадна тохижилт, инженерийн шугам сүлжээ, сургууль, цэцэрлэг болон дэд төвүүдийг барих зорилгоор газар чөлөөлөх, нөхөх олговор олгоход шаардлагатай нийт 3511 нэгж талбарыг хэсэгчлэн болон бүтэн чөлөөлсөн байна. Үүнээс 3478 нэгж талбар буюу 99.06 хувь нь нөхөх олговрын хөрөнгөө бүрэн хүлээн авсан бөгөөд 33 нэгж талбар буюу 0.94 хувь нь холбогдох шалтгааны улмаас нөхөх олговроо бүрэн аваагүй, тодорхой хугацаанд саатсан байна. Санхүүжилт

удааширсан 33 нэгж талбараас нөхөх олговрын санхүүжилтийг бүрэн олгосон 11 нэгж талбарын анхны санхүүжилт олгосноос хойш эцсийн санхүүжилт олгох хүртэл ойролцоогоор 4-10 сарын хугацаа зарцуулсан байна.

Нөхөн олговрын санхүүжилт удаашрахад иргэн, хуулийн этгээдийн баримт бичгийн бүрдүүлэлт, банкны барьцаа, зээлийн асуудал, нүүлгэн шилжүүлэх болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шинэ байршил шийдвэрлэх зэрэг нөхцөл голлон нөлөөлжээ. Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

3.2.Улсын хэмжээнд 2023-2025 оны хооронд Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр газартай холбоотой 1577 маргааныг хянан шийдвэрлэсэн байна. Энэ нь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нийт маргааны 22 хувийг эзэлж байна.

Газрын тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр нийслэлийн хэмжээнд Газрын эрхийн маргаан таслах зөвлөл байгуулах эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан. Ингэснээр иргэн, хуулийн этгээдийн газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй холбоотой үүссэн маргааныг шүүхийн байгууллагад хандахаас өмнө урьдчилан шийдвэрлэх боломжтой болсон. 2025-2026 оны байдлаар Газрын эрхийн маргаан таслах зөвлөлөөр нийт 304 гомдлыг хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, газрын эрхийн маргааныг шуурхай шийдвэрлэх боломж бүрдсэн. Үүний үр дүнд шүүхээр шийдвэрлэгдэж буй газрын эрхийн маргааны тоо өмнөх онтой харьцуулахад 13 хувиар буурсан эерэг үр дүн гарсан болно. Цаашид газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааг улсын хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд энэ зохицуулалтыг тусгаад байна.

ДӨРӨВ. Газрын төлбөр, бүсчлэл, үнэлгээний талаар:

4.1.Улсын хэмжээнд газрын төлбөрийн орлогоос 2021 онд 112.7 тэрбум төгрөг, 2022 онд 117.9 тэрбум төгрөг, 2023 онд 140.5 тэрбум төгрөг, 2024 онд 142.2 тэрбум төгрөг, 2025 онд 134.1 тэрбум төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Газрын төлбөрийн тухайн хуулийн 10 дугаар зүйлийн 2-т “Газрын төлбөрийн орлогын зохих хувийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаагаас бусад төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд зориулан зарцуулна. Тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, газрын төлбөрөөс орох орлогыг харгалзан газар хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд зориулан зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг Засгийн газар жил бүр тогтооно” гэж заасны дагуу улс, орон нутгийн төсөвт газрын хянан баталгааны ажил гүйцэтгэх, газар хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх, төрөл бүрийн масштабын байр зүйн зураг зохиох, GNSS-ийн байнгын ажиллагаатай станц шинээр байгуулах зэрэг ажил, арга хэмжээнд зориулан хөрөнгө батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4.2.Хот дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц, газар ашиглалтын зориулалт, байршил, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон ногоон бүсийг хамгаалах шаардлагыг харгалзан тухайн орчинд тохирсон үнэлгээний зэрэглэл (бүс)-д хамааруулан итгэлцүүр болон түүнийг хэрэглэх газрын зааг хязгаарыг

тогтоох, газрын төлбөрийн хувьд нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан иргэн, хуулийн этгээдийн төлөх төлбөрийн хэмжээнд нөлөө үзүүлэхгүй байх зарчмыг баримтлан газрын суурь үнэлгээг шинэчлэн боловсруулах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Ингэснээр тухайн орчны бүтээн байгуулалт, инженерийн дэд бүтэц, хөгжлийн нөлөөгөөр үнэ цэнэ нь нэмэгдэж байгаа бодит нөхцөл байдалд нийцсэн үнэлгээний бүсэд хамруулах, газрын үнэ цэнийг бууруулахгүй байх, газрын төлбөр, татварыг тэгш шударга тогтоох боломжууд бүрдэх юм.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 128 дугаар захирамжаар Ажлын хэсэг байгуулан Газрын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Газрын төлбөрийн тухай, Хаягжуулалтын тухай, Геодези, зураг зүйн тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төслийг тус тус боловсруулж, Улсын Их Хурлын намрын чуулганд багтаан өргөн барьж, хэлэлцүүлэхээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Уг хуулийн төслөөр газрын суурь үнэлгээ тогтоох, газрын төлбөр, татварын хувь хэмжээг зөв тооцох асуудлыг нарийвчлан тусгаж байгаа болно.

Холбогдох тоон мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 10 хуудастай.



Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
Дарга
А.Энхманлай
2026.09.11 10:48

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын
2026 оны 1/522 дугаар аялан бичгийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ХҮСЭЛТИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 1. Улсын хэмжээнд 2023, 2024, 2025 онуудад иргэдээс гаргасан гэр, орон сууц хашааны газрын зориулалтаар газар эзэмших хүсэлтийн тоо.

№	Аймаг	2023 он		2024 он		2025 он	
		Цахимаар хүсэлт гаргасан	Цаасан байдлаар хүсэлт гаргасан	Цахимаар хүсэлт гаргасан	Цаасан байдлаар хүсэлт гаргасан	Цахимаар хүсэлт гаргасан	Цаасан байдлаар хүсэлт гаргасан
1	Архангай	0	1197	1385	133	2717	132
2	Баян-Өлгий	0	1446	1577	91	878	65
3	Баянхонгор	0	745	2935	157	725	30
4	Булган	0	3363	3572	221	1801	22
5	Говь-Алтай	0	1321	271	275	914	411
6	Говьсүмбэр	0	81	387	75	272	23
7	Дархан-Уул	0	457	38	47	2330	88
8	Дорноговь	0	853	1114	190	1234	162
9	Дорнод	0	937	2280	128	899	20
10	Дундговь	0	308	372	59	181	40
11	Завхан	0	992	868	154	784	77
12	Орхон	0	1220	5137	335	1561	46
13	Сэлэнгэ	0	1169	5159	331	3109	152
14	Сүхбаатар	0	284	1182	27	1170	60
15	Төв	1	3450	13924	463	6384	203
16	Увс	0	2473	1441	463	1133	11
17	Ховд	0	1145	720	276	433	73
18	Хэнтий	0	1702	1682	217	724	31
19	Хөвсгөл	1	2388	763	235	4141	129
20	Өвөрхангай	0	1124	473	53	1797	78
21	Өмнөговь	0	413	20	94	966	78
22	Улаанбаатар	3	31631	1314	9997	38746	10930
Нийт		5	58699	46614	14021	72899	12861

Хүснэгт 2. Нийслэлийн хэмжээнд 2023, 2024, 2025 онуудад иргэдээс гаргасан гэр, орон сууц хашааны газрын зориулалтаар газар эзэмших хүсэлтийн тоо.

№	Дүүрэг	2023		2024		2025	
		Цахимаар хүсэлт гаргасан	Цаасан хэлбэрээр гаргасан	Цахимаар хүсэлт гаргасан	Цаасан хэлбэрээр гаргасан	Цахимаар хүсэлт гаргасан	Цаасан хэлбэрээр гаргасан
1	Багануур	0	722	0	42	1168	229
2	Багахангай	0	557	234	200	3908	121
3	Баянгол	0	62	0	10	767	97
4	Баянзүрх	2	11150	2	3244	9398	5450
5	Налайх	0	1877	1077	2004	3995	694
6	Сонгинохайрхан	1	8378	0	2455	8638	2705
7	Сүхбаатар	0	2993	0	155	2389	372
8	Хан-Уул	0	5022	1	1221	6210	619
9	Чингэлтэй	0	870	0	666	2273	643
Нийт		3	31631	1314	9997	38746	10930

Хүснэгт 3. Улсын хэмжээнд 2026 оны байдлаар иргэн, хуулийн этгээдээс ирсэн 27 төрлийн цахим хүсэлтийн тоо, шийдвэрлэгдсэн байдал.

Д/Д	Аймаг, нийслэл	Нийт	Үүнээс	
			Шийдсэн	Хянагдаж байгаа
1	Архангай	10743	8948	1795
2	Баян-Өлгий	7975	6287	1688
3	Баянхонгор	8009	5913	2096
4	Булган	13645	9515	4130
5	Говь-Алтай	5502	3379	2123
6	Говьсүмбэр	2596	2368	228
7	Дархан-Уул	11094	10498	596
8	Дорноговь	7063	5779	1284
9	Дорнод	7980	6688	1292
10	Дундговь	2494	2080	414
11	Завхан	5412	4069	1343
12	Орхон	15176	13090	2086
13	Сэлэнгэ	17765	15500	2265
14	Сүхбаатар	5772	5275	497
15	Төв	44041	39324	4717
16	Увс	10093	6401	3692
17	Ховд	6334	4958	1376
18	Хэнтий	8218	6041	2177
19	Хөвсгөл	15012	12223	2789
20	Өвөрхангай	9216	7833	1383
21	Өмнөговь	5417	4634	783
22	Улаанбаатар	248843	199968	48875
Нийт		468400	380771	87629

Хүснэгт 4. Улсын хэмжээнд 2023 онд иргэдээс гаргасан шинээр газар эзэмших хүсэлтийн тоо.

№	Аймаг	2023 он							
		Цахим хүсэлт	Үүнээс			Цаасан хэлбэрээр	Үүнээс		
			Шийдвэр лэсэн	Судлагдаж байгаа	Шийдвэр лэсэн дундаж хоног		Шийдвэр лэсэн	Судлагдаж байгаа	Шийдвэр лэсэн дундаж хоног
1	Архангай	0	0	0		1197	1166	28	97.4
2	Баян-Өлгий	0	0	0		1446	1408	38	115.7
3	Баянхонгор	0	0	0		745	727	18	148.1
4	Булган	0	0	0		3363	3347	16	128.9
5	Говь-Алтай	0	0	0		1321	1218	103	84.2
6	Говьсүмбэр	0	0	0		81	76	5	31.2
7	Дархан-Уул	0	0	0		457	450	7	148.4
8	Дорноговь	0	0	0		853	830	23	38.4
9	Дорнод	0	0	0		937	891	46	116.5
10	Дундговь	0	0	0		308	303	5	176.8
11	Завхан	0	0	0		992	966	26	73.5
12	Орхон	0	0	0		1220	1145	75	175.3
13	Сэлэнгэ	0	0	0		1169	1103	63	102.1
14	Сүхбаатар	0	0	0		284	273	11	99.4
15	Төв	1	0	1		3450	3354	96	159.4
16	Увс	0	0	0		2473	2392	81	185.1
17	Ховд	0	0	0		1145	1020	124	156
18	Хэнтий	0	0	0		1702	1657	45	116.2

19	Хөвсгөл	1	0	1		2388	2195	193	104.5
20	Өвөрхангай	0	0	0		1124	1112	12	142.6
21	Өмнөговь	0	0	0		413	397	16	106.8
22	Улаанбаатар	3	0	3		31631	26042	5589	202.6
	Нийт	5	0	5	0	58699	52072	6620	119

Хүснэгт 5. Улсын хэмжээнд 2024 онд иргэдээс гаргасан шинээр газар эзэмших хүсэлтийн тоо.

№	Аймаг	2024 он							
		Цахим хүсэлт	Үүнээс			Цаасан хэлбэрээр	Үүнээс		
			Шийдвэр лэсэн	Судлагдаж байгаа	Шийдвэр лэсэн дундаж хоног		Шийдвэр лэсэн	Судлагдаж байгаа	Шийдвэр лэсэн дундаж хоног
1	Архангай	1385	120	1	150.5	133	128	5	77.8
2	Баян-Өлгий	1577	62	35	119.3	91	74	17	68.4
3	Баянхонгор	2935	1169	0	115.9	157	139	18	182.3
4	Булган	3572	535	3	148.9	221	217	4	64.7
5	Говь-Алтай	271	109	37	155.6	275	241	34	66.4
6	Говьсүмбэр	387	50	1	156.8	75	70	5	107.8
7	Дархан-Уул	38	0	0		47	46	1	64.6
8	Дорноговь	1114	75	9	252.4	190	185	5	48.4
9	Дорнод	2280	244	5	182.2	128	122	6	86.1
10	Дундговь	372	14	0	225.2	59	51	8	144.1
11	Завхан	868	102	6	148.8	154	146	8	72.6
12	Орхон	5137	373	2	204.1	335	274	61	195.5
13	Сэлэнгэ	5159	307	27	160.3	331	304	27	63.8
14	Сүхбаатар	1182	55	0	119.3	27	26	1	71.8
15	Төв	13924	476	52	187	463	438	25	123.1
16	Увс	1441	638	42	132.9	463	435	28	139.2
17	Ховд	720	0	2		276	255	21	88.6
18	Хэнтий	1682	253	3	220.2	217	214	3	96.1
19	Хөвсгөл	763	85	29	180.2	235	199	36	111.3
20	Өвөрхангай	473	35	0	152	53	53	0	97.1
21	Өмнөговь	20	0	3		94	93	1	70.1
22	Улаанбаатар	1314	170	1144	128.1	9997	6195	3802	218.2
	Нийт	46614	4872	1401	165	14021	9905	4116	101

Хүснэгт 6. Улсын хэмжээнд 2025 онд иргэдээс гаргасан шинээр газар эзэмших хүсэлтийн тоо.

№	Аймаг	2025 он							
		Цахим хүсэлт	Үүнээс			Цаасан хэлбэрээр гаргасан	Үүнээс		
			Шийдвэр лэсэн	Судлагдаж байгаа	Шийдвэр лэсэн дундаж хоног		Шийдвэр лэсэн	Судлагдаж байгаа	Шийдвэр лэсэн дундаж хоног
1	Архангай	2717	87	2630	126.7	132	119	13	20.3
2	Баян-Өлгий	878	30	848	83.3	65	63	2	43.9
3	Баянхонгор	725	4	721	11.0	30	27	3	69.9
4	Булган	1801	0	1801		22	22	0	25.2
5	Говь-Алтай	914	14	900	86.6	411	400	11	52.6
6	Говьсүмбэр	272	0	272		23	23	0	47.9
7	Дархан-Уул	2330	0	2330		88	86	2	110.8
8	Дорноговь	1234	2	1232	9.0	162	161	1	43.3
9	Дорнод	899	0	899		20	19	1	39.2
10	Дундговь	181	1	180	13.0	40	36	4	32.2
11	Завхан	784	18	766	156.6	77	73	4	42.3

12	Орхон	1561	0	1561		46	38	8	211.8
13	Сэлэнгэ	3109	6	3103	86.3	152	145	7	36.1
14	Сүхбаатар	1170	15	1155	74.9	60	56	4	68.8
15	Төв	6384	25	6359	48.0	203	170	33	76.6
16	Увс	1133	11	1122	117.3	11	10	1	38.6
17	Ховд	433	1	432	165.0	73	62	11	58.1
18	Хэнтий	724	0	724		31	27	4	61.7
19	Хөвсгөл	4141	61	4080	89.4	129	106	23	39
20	Өвөрхангай	1797	5	1792	68.4	78	75	3	13
21	Өмнөговь	966	1	965	27.0	78	72	6	76.6
22	Улаанбаатар	38746	0	38746	169.2	10930	7084	3846	101.2
Нийт		72899	281	72618	77	12861	8874	3987	60

ГАЗРЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 7. Дуудлага худалдаа зохион байгуулсан тоо, оролцогч, орлого тэрбум төгрөг /2020-2025 он/

Он	Зохин байгуулсан тоо	Үүнээс		Нийт оролцогч	Үүнээс		Нийт орлого	Үүнээс	
		Цахим	Танхим		Цахим	Танхим		Цахим	Танхим
2020	2,282	1,968	314	3,590	3,245	345	10.4	7.6	2.8
2021	2,383	2,169	214	4,410	4,120	290	14.7	13.5	1.2
2022	4,225	3,932	293	7,474	7,066	408	42.9	29.8	14.1
2023	2,957	2,564	393	5,628	5,175	453	23.7	19.9	3.8
2024	2,158	1,731	425	6,160	4,944	1,216	26.1	16.3	9.8
2025	1,264	1,059	205	3,636	2,910	726	37.4	22.6	14.8
Нийт	15,267	13,423	1,844	30,898	27,460	3,438	155.2	109.7	46.5

Хүснэгт 8.2025 онд дуудлага худалдаагаар олгохоор төлөвлөгдсөн нэгж талбар, түүний хэрэгжилт

Д/д	Аймаг, нийслэл	Дуудлага худалдаагаар олгохоор төлөвлөсөн		Дуудлага худалдаагаар олгосон биелэлт		Хэрэгжилтийн хувь
		Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ-(га)	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ-(га)	
1	Архангай	45	23.68	25	8.57	55.6%
2	Баян-Өлгий	46	50.01	10	17.18	21.7%
3	Баянхонгор	41	373.24	23	3.94	56.1%
4	Булган	60	122.95	38	74.50	63.3%
5	Говь-Алтай	42	269.61	15	3.15	35.7%
6	Говьсүмбэр	11	711.39	6	106.40	54.5%
7	Дархан-Уул	103	204.49	48	59.73	46.6%
8	Дорноговь	201	951.16	55	547.89	27.4%
9	Дорнод	49	2738.99	20	158.52	40.8%
10	Дундговь	182	546.58	68	143.66	37.4%
11	Завхан	86	1182.69	60	324.35	69.8%
12	Орхон	24	624.66	13	3.79	54.2%
13	Өвөрхангай	42	347.61	17	11.25	40.5%
14	Өмнөговь	51	387.84	20	139.94	39.2%
15	Сүхбаатар	26	154.40	16	122.34	61.5%
16	Сэлэнгэ	105	189.29	54	82.52	51.4%
17	Төв	152	2128.95	46	1380.74	30.3%
18	Увс	49	28.45	5	3.17	10.2%
19	Ховд	67	198.77	15	54.42	22.4%

20	Хөвсгөл	68	413.08	37	394.00	54.4%
21	Хэнтий	38	154.90	17	101.16	44.7%
22	Улаанбаатар	105	189.88	49	87.95	46.7%
Нийт		1593	11992.66	657	3829.16	41.2%

**ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН
МЭДЭЭЛЭЛ**

*Хүснэгт 9.2025 онд төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор төлөөлөгдсөн нэгж талбар,
түүний хэрэгжилт*

Д/д	Аймаг, нийслэл	Төсөл сонгон шалгаруулах зарчмаар төлөвлөсөн		Төсөл сонгон шалгаруулах зарчмаар олгосон биелэлт	
		Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ (га)	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ (га)
1	Архангай	55	234.711	25	120.36
2	Баян-Өлгий	2	54.1529	2	54.15
3	Баянхонгор	25	71.4488	8	18.32
4	Булган	45	157.821	24	101.07
5	Говь-Алтай	1	84		
6	Говьсүмбэр	9	43.3	1	3.30
7	Дархан-Уул	53	135.441	5	17.50
8	Дорноговь	26	97178.3	5	18.58
9	Дорнод	13	24.5		
10	Дундговь	23	72.4807	1	5.00
11	Завхан	109	540.092	5	24.97
12	Орхон	6	24.708	5	23.13
13	Өвөрхангай	22	101.803	1	22.50
14	Өмнөговь	22	109.532	11	23.94
15	Сүхбаатар	5	21.5103	3	15.00
16	Сэлэнгэ	28	191.907	15	72.91
17	Төв	44	565.21	6	29.87
18	Увс	22	45.3866	2	1.21
19	Ховд	12	47.8363	2	5.21
20	Хөвсгөл	64	175.499	18	85.23
21	Хэнтий	42	169.985	37	140.50
22	Улаанбаатар	26	74.2651	4	19.97
Нийт		654	100124	180	802.73

НӨХӨН ОЛГОВОР БОЛОН ГАЗРЫН МАРГААНТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

*Хүснэгт 10.Нийслэлийн хэмжээнд газар чөлөөлөлтийн нөхөн олговрын санхүүжилт
удааширсан тохиолдлуудын тайлбар жагсаалт (33 нэгж талбар)*

№	Он	Нэгж талбарын дугаар	Тайлбар (шалтгаан)	Үлдэгдлийн мэдээлэл
1	2023	1500713939	Тухайн хуулийн этгээд нь үл хөдлөх эд хөрөнгө бүтнээр нь нөхөх олговортойгоор чөлөөлөхөөр гэрээ байгуулсан боловч авто замын трассын нөлөөлөлд өртсөн хэсгийг буулгаж үлдсэн хэсгийг чөлөөлж гэрээний үүргээ биелүүлээгүй	Нийт нөхөх олговроос 20 хувийн үлдэгдэлтэй. Эхний санхүүжилт 8/15/2023 ологдсон.
2	2024	1461500557, 18643312215485	Сүхбаатар дүүргийн 9, 10, 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хийх "Явган зам, дугуйн зам"-ын	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтыг 12/27/2024-нд шилжүүлсэн.

№	Он	Нэгж талбарын дугаар	Тайлбар (шалтгаан)	Үлдэгдлийн мэдээлэл
			ажлын нөлөөлд өртсөн замын трасс чөлөөлсөн газар нь банкны барьцаанд байгаа тул үлдэгдэл төлбөрийг шилжүүлээгүй	
3	2024	18635312931797, 1800803518	Иргэн М.Уранзаяа нь 2018 онд өрхийн бизнес эхлүүлэхээр банк болон банк бус санхүүгийн байгууллагаас 90 сая төгрөгийн зээл авсан ба улмаар COVID-19 цар тахал гарч үйл ажиллагаагаа зогсоосон. Тухайн авсан зээлийн үлдэгдэл болон 42 сая төгрөгийг 2026 оны 9 дүгээр сард төлж барагдуулах ба холбогдох бичиг баримтаа банкнаас чөлөөлнө гэж өргөдөлдөө дурдсан болно.	Нийт нөхөх олговроос 10 хувийн үлдэгдэлтэй. Эхний санхүүжилтийг 11/13/2024-нд шилжүүлсэн.
4	2024	1332100914	Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт тавигдах "Жишиг гудамж төслийн хүрээнд шинээр баригдах авто зам"-ын санхүүжилт татагдсантай холбоотой Авто замын ажил зогссон тул иргэд газраа чөлөөлөхгүй	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлтэй. Эхний санхүүжилтийг 12/16/2024-нд шилжүүлсэн.
5	2024	1332501885	Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт тавигдах "Жишиг гудамж төслийн хүрээнд шинээр баригдах авто зам"-ын санхүүжилт татагдсантай холбоотой Авто замын ажил зогссон тул иргэд газраа чөлөөлөхгүй Авто замын ажил зогссон	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 12/16/2024-нд шилжүүлсэн.
6	2024	1332501788	Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт тавигдах "Жишиг гудамж төслийн хүрээнд шинээр баригдах авто зам"-ын санхүүжилт татагдсантай холбоотой Авто замын ажил зогссон тул иргэд газраа чөлөөлөхгүй Авто замын ажил зогссон	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 12/27/2024-нд шилжүүлсэн.
7	2024	18644312450964, 1332501775	Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт тавигдах "Жишиг гудамж төслийн хүрээнд шинээр баригдах авто зам"-ын санхүүжилт татагдсантай холбоотой Авто замын ажил зогссон тул иргэд газраа чөлөөлөхгүй Авто замын ажил зогссон	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 12/27/2024-нд шилжүүлсэн.
8	2024	1461602088	Сэлбэ голын баруун эрэг дагуух 2.5 км авто зам /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ замын трасс өөрчлөгдсөнтэй холбоотой газраа бүтнээр нь авахаар болж зөвшилцөх ажил хийгдэж байгаа.	Нийт нөхөх олговроос 20 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 12/27/2024-нд шилжүүлсэн.
9	2025	1800802866	Иргэн Н.Чагнаадорж нь 2016 онд газраа болон дугуй засварын ажлын байраа Хаан банкны барьцаанд өгч зээл авсан. Улмаар авсан зээлтэй холбоотойгоор маргаан үүссэн ба 2024 оноос хойш шүүхээр шийдвэрлүүлэхээр	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 12/17/2024-нд шилжүүлсэн.

№	Он	Нэгж талбарын дугаар	Тайлбар (шалтгаан)	Үлдэгдлийн мэдээлэл
			явж байгаа тухайгаа биечлэн ирж тайлбар өгсөн.	
10	2025	1800803066	Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах "Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллыг орон сууцжуулах" ажилд хамрагдсан боловч эд хөрөнгийн маргаантай тул үлдэгдэл мөнгийг санхүүжүүлээгүй	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 10/23/2025-нд шилжүүлсэн.
11	2025	1801303144	Газраа чөлөөлсөн гүйцэтгэлийн актыг хийж Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн	Эхний санхүүжилтийг 10/31/2025-нд шилжүүлсэн. 40 хувийн үлдэгдэлийг 8/19/2026 шилжүүлсэн.
12	2025	1801303314	Газраа чөлөөлсөн гүйцэтгэлийн актыг хийж Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 12/1/2025-нд шилжүүлсэн.
13	2025	1800803569	Өрх толгойлсон эмэгтэй ба 3 ам бүлийн хамт 1 хашаанд оршин суудаг. Эд хөрөнгийн үнэлгээгээр үнэлгээний дүн бага гарч дараагийн амьдрах орчны нөхцөл бүрдэхгүй гэдэг шалтгаанаар газраа чөлөөлөөгүй 6 сар орчим болсон. НОСБГ болон НОСК-тай хамтран тухайн иргэнд ахмадын орон сууц төслөөс 1 өрөө байрыг нэмж олгохороор шийдвэрлэж газар чөлөөлөх гэрээ байгуулан ажилласан. Энэхүү орон сууц олгох асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа болно. Өнөөгийн байдлаар гэрээний нэмэлт нөхцөл хангагдаагүй байна.	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 12/24/2025-нд шилжүүлсэн.
14	2025	1800803180	Өмчлөлийн газартаа авто засварын үйл ажиллагаа эрхлэдэг. Эд хөрөнгийн үнэлгээгээр гарсан үнэлгээний дүн бага гарсан тул өрхийн бизнесийн үйл ажиллагаагаа алдаж байна, дахин ийм байршил олж үйл ажиллагаагаа явуулах боломжгүй гэдэг шалтгаанаар 6 сар татгалзаад байсан. Үүнтэй холбоотойгоор НОСБГ болон НОСК-тай хамтран тус иргэнд ахмадын орон сууц төслөөс 1 өрөө байрыг нэмж олгохороор шийдвэрлэж газар чөлөөлөх гэрээ байгуулан ажилласан. Энэхүү орон сууц олгох асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа болно. Гэрээний нэмэлт нөхцөл хангагдаагүй байна.	Нийт нөхөх олговроос 20 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 12/19/2025-нд шилжүүлсэн.
15	2025	1802403668	Тус иргэнд хашаа болон үл хөдлөх хөрөнгө байхгүй бөгөөд тус хаяг дээр огт амьдардаггүй. Иргэн А.Одончимэг нь архины хамааралтай бөгөөд тогтсон утасны дугаар болон оршин суух хаяг байхгүй. Тухайн иргэнийг Наркалогийн үндэсний төвөөс архины албадан эмчилгээ хийлгэж байх үед нь олж нөхөх олговрын 80% -ыг олгох	Нийт нөхөх олговроос 20 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 12/19/2025-нд шилжүүлсэн.

№	Он	Нэгж талбарын дугаар	Тайлбар (шалтгаан)	Үлдэгдлийн мэдээлэл
			гүйцэтгэлийн гэрээ хийж байсан. Үлдэгдэл 20%-ыг олгохоор Наркалогийн үндэсний төв болон СХД-ийн 9 дүгээр хорооны хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан, цагдаагийн байгууллага гэх зэрэг хариуцсан хүмүүсээс лавлахад холбож өгч чадаагүй. Тус иргэнтэй холбоо барих утасгүй, тогтсон оршин суух хаяггүй, архины хамааралтай, ар гэр ах дүү гэх хүмүүс байхгүй гэх зэрэг шалтгаануудаас үүдэж үлдэгдэл нөхөх олговрын мөнгийг олгож чадахгүй байна. Ар гэрийн байдал нь нөхөргүй 2 хүүхэдтэй бөгөөд түүний 2 хүүхэд харааны бэрхшээлтэй ба асрамжийн газар харъяалагддаг болно.	
16	2025	18634311686552	Газраа чөлөөлсөн гүйцэтгэлийн актыг хийж Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 2/11/2026-нд шилжүүлсэн.
17	2025	1800702561	Газраа чөлөөлсөн гүйцэтгэлийн актыг хийж Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн	Эхний санхүүжилтийг 2/11/2026-нд шилжүүлсэн. Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэл санхүүжилтийг 7/7/2026-нд шилжүүлсэн.
18	2025	1800702596	Газраа чөлөөлсөн гүйцэтгэлийн актыг хийж Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 2/11/2026-нд шилжүүлсэн.
19	2025	1681200004	Газраа чөлөөлсөн Газрын төлбөрийн үлдэгдэлтэй тул газрын хасалт хийх хүсэлт бүртгэх боломжгүй байгаа.	Нийт нөхөх олговроос 10 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 11/3/2025-нд шилжүүлсэн.
20	2025	1332605318	Газраа чөлөөлөөгүй	Нийт нөхөх олговроос 10 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 11/14/2025-нд шилжүүлсэн.
21	2025	1800504245	Гадаадад байдаг итгэмжилсэн төлөөлөгч солиулах хүсэлтэй	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 11/19/2025-нд шилжүүлсэн.
22	2025	1800405430	Газар чөлөөлсөн, гадаадад итгэмжлэлийн асуудалтай	Эхний санхүүжилтийг 11/27/2025-нд шилжүүлсэн. Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг 7/28/2026-нд шилжүүлсэн.
23	2025	1461600660	Газраа чөлөөлөөгүй	Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 7/28/2026-нд шилжүүлсэн.
24	2025	1461601876	Газраа чөлөөлсөн гүйцэтгэлийн актыг хийж Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн	Эхний санхүүжилтийг 12/17/2025-нд шилжүүлсэн. Нийт нөхөх олговроос 10 хувийн үлдэгдэлийг 7/3/2026-нд шилжүүлсэн.
25	2025	1461601957	Газраа чөлөөлсөн гүйцэтгэлийн актыг хийж Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн	Эхний санхүүжилтийг 12/23/2025-нд шилжүүлсэн. Нийт нөхөх олговроос 10 хувийн үлдэгдэлийг 7/9/2026-нд шилжүүлсэн.
26	2025	1461601934	Газраа чөлөөлсөн гүйцэтгэлийн актыг хийж Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн	Эхний санхүүжилтийг 12/25/2025-нд шилжүүлсэн. Нийт нөхөх олговроос 10 хувийн үлдэгдэлийг 8/19/2026-нд шилжүүлсэн.

№	Он	Нэгж талбарын дугаар	Тайлбар (шалтгаан)	Үлдэгдлийн мэдээлэл
27	2025	1681900012	Газраа чөлөөлсөн гүйцэтгэлийн актыг хийж Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн	Эхний санхүүжилтийг 12/25/2025-нд шилжүүлсэн. Нийт нөхөх олговроос 10 хувийн үлдэгдэлийг 8/3/2026-нд шилжүүлсэн.
28	2025	1681910037	Газраа чөлөөлсөн гүйцэтгэлийн актыг хийж Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн	Эхний санхүүжилтийг 12/25/2025-нд шилжүүлсэн. Нийт нөхөх олговроос 10 хувийн үлдэгдэлийг 8/19/2026-нд шилжүүлсэн.
29	2025	1802301853	СХД-ийн 5 дугаар хороо, Бэйсболын талбайн төсөлд өртсөн газрын эрхийн гэрчилгээ барьцаанд байсан тул барьцаанаас чөлөөлөх ажиллагаа удааширч, газар чөлөөлөлтийн хугацаа сунжирсан.	Эхний санхүүжилтийг 8/18/2025-нд шилжүүлсэн. Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг 7/8/2026-нд шилжүүлсэн.
30	2025	1802300606	Самбууням, СХД-ийн 27 дугаар хороо, Шүүхийн барилгын төсөлд өртсөн барилгад хулгай гарч, цагдаагийн байгууллагад шалгагдаж байсан тул барилга буулгах ажил хугацаа алдсан.	Эхний санхүүжилтийг 11/27/2025-нд шилжүүлсэн. Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг 7/9/2026-нд шилжүүлсэн.
31	2025	1781611010	Уг хуулийн этгээд нь нөхөх олговортойгоор газар чөлөөлсний дараа үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шинэ байршил олдоогүйгээс нүүлгэн шилжүүлэх ажил удааширсан.	Эхний санхүүжилтийг 12/25/2025-нд шилжүүлсэн. Нийт нөхөх олговроос 40 хувийн үлдэгдэлийг 7/8/2026-нд шилжүүлсэн.
32	2025	1501514576	Иргэн Э.Хоролсүрэн нь 2025 оны 08 дугаар сард нөхөх олговрын 80% авсан. Банкний зээлээр хүнсний дэлгүүр ажиллуулдаг амжиргаагаа хэвийн авч үлдэхийн түлд 80%-ийн санхүүжилтаар өөр байршилд бизнес хийх, нөхөх олговрын мөнгөөр бизнес үргэлжлүүлэх боломжгүй байна.	Нийт нөхөх олговроос 20 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 8/1/2025-нд шилжүүлсэн.
33	2025	1501012976, 18643316142661	Иргэн Б.Цэндсүрэн нь эрүүл мэндийн шалтгаанаар гадаадад эмчилгээ хийлгэж байгаа тул үлдэгдэл төлбөрөө аваагүй байна. 2026 оны 09 дүгээр сарын 15-нд монгол ирж үлдэгдэл 20%-ийг авахаар тохирсон.	Нийт нөхөх олговроос 20 хувийн үлдэгдэлийг аваагүй. Эхний санхүүжилтийг 9/29/2025-нд шилжүүлсэн.

Тайлбар: 33 нэгж талбараас нөхөх олговрын санхүүжилтийг бүрэн олгосон 11 нэгж талбарын анхны санхүүжилт олгосноос эцсийн төлбөрийг бүрэн шилжүүлэх хүртэл дунджаар 229 хоног буюу ойролцоогоор 7 сар зарцуулсан байна. Үүнээс хамгийн богино хугацаа 146 хоног буюу 4 сар, хамгийн урт хугацаа 324 хоног буюу 10 сар байна. Санхүүжилт олголтын хугацаа уртсахад иргэн, хуулийн этгээдийн баримт бичгийн бүрдүүлэлт, банкны барьцаа болон зээлийн асуудал, нүүлгэн шилжих болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шинэ байршил шийдвэрлэх зэрэг нөхцөл голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба.

ГАЗРЫН ТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

Газрын төлбөрийн орлогоос 2021 онд 112.7 тэрбум төгрөг, 2022 онд 117.9 тэрбум төгрөг, 2023 онд 140.5 тэрбум төгрөг, 2024 онд 142.2 тэрбум төгрөг, 2025 онд 134.1 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 11. Газрын төлбөрийн төлөвлөгөө болон гүйцэтгэл /он тус бүрээр/

Он	Газрын төлбөрийн төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Гүйцэтгэл /%/
1998	1,919.60	1,524.50	80

1999	2,678.60	1,764.20	66
2000	3,221.50	2,895.00	90
2001	4,673.60	5,401.90	116
2002	5,570.70	6,163.10	110
2003	7,303.40	7,962.00	109
2004	11,840	11,795.20	99
2005	13,867.60	14,045.20	101
2006	14,323.00	15,780.70	110
2007	19,786.80	20,093.70	102
2008	24,790.40	25,543.40	102
2009	28,006.60	29,472.40	105
2010	29,311.70	30,448.60	104
2011	31,280.70	33,556.80	107
2012	39,031.30	43,623.20	112
2013	37,912.00	43,185.10	114
2014	42,326.90	44,950.90	106
2015	45,712.60	44,556.20	97
2016	47,002.60	46,940.40	99.9
2017	47,683.40	49,361.90	103.5
2018	48,875.90	51,616.90	105.6
2019	76,426.80	88,070.90	115.2
2020	125,070.00	107,413.30	86.4
2021	158,960.00	112,691.30	70.9
2022	154,322.00	117,924.20	76.4
2023	156,325.40	140,488.60	90
2024	160,856.10	142,181.80	88.4
2025	184,241.40	134,012.40	73
Нийт	1,523,320.60	1,373,463.80	91

Хүснэгт 12. 2025 оны газрын төлбөрийн төлөвлөгөө болон гүйцэтгэл /аймаг, нийслэлээр/

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Газрын төлбөрийн төлөвлөгөө (сая.төг)	Тайлангийн хугацаанд төлсөн төлбөр (сая.төг)	Гүйцэтгэлийн хувь
0	1	2	4	5
1	Архангай	334.0	570.6	170.8
2	Баян-Өлгий	606.8	458.2	75.5
3	Баянхонгор	859.0	866.2	100.8
4	Булган	1,795.0	1,815.5	101.1
5	Говь-Алтай	2,104.1	1,935.2	92
6	Говьсүмбэр	526.0	976.0	185.6
7	Дархан-Уул	2,259.0	2,119.2	93.8
8	Дорнод	2,666.4	2,508.9	94.1
9	Дундговь	5,000.0	1,642.5	32.9
10	Завхан	1,030.0	1,065.8	103.5
11	Орхон	31,505.0	28,913.3	91.8
12	Өвөрхангай	1,188.7	994.2	83.6
13	Өмнөговь	14,052.2	14,494.7	103.1
14	Сүхбаатар	444.7	671.7	151
15	Сэлэнгэ	2,473.2	2,262.8	91.5
16	Төв	3,836.6	3,586.1	93.5
17	Увс	969.9	742.2	76.5
18	Ховд	1,410.9	1,193.6	84.6
19	Хөвсгөл	645.7	731.3	113.3
20	Хэнтий	1,230.9	1,341.0	109
21	Дорноговь	6,921.6	4,215.4	60.9
22	Нийслэл	102,381.0	60,906.3	59.5
нийт		184,241.4	134,012.4	73

—оОо—



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 71 99

Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2026.08.31 № 03/5505

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

Танаас 2026 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн
"Асуулгын хариу ирүүлэх тухай" ХЭГ/2802 дугаартай
албан бичгээр ирүүлсэн Газрын тухай хууль тогтоомжийн
хэрэгжилтийн талаарх асуулгын хариуг хавсралтаар
хүргүүлж байна.

Хавсралт 96 хуудастай.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙН ТҮН ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ү.ГАНБОЛД

1726193596

10704 Очирпүрэв

אָפּטאַג, און אַלע אַנדערע אַרבעטן

ਸਿਰਿਸਤਾਨੀ ਦੇ ਸਿਰਿਸਤਾਨੀ ਦੇ ਸਿਰਿਸਤਾਨੀ ਦੇ ਸਿਰਿਸਤਾਨੀ ਦੇ



1726201592

«የኢትዮጵያ ፌዴራላዊ ዲሞክራሲያዊ ሪፐብሊክ» የሚለውን ስም
 በፍጥነት ለማሻሻልና ለማጠናከር ለሚችልበት ሁኔታ ማድረግ
 «የኢትዮጵያ ፌዴራላዊ ዲሞክራሲያዊ ሪፐብሊክ» በ- ፩-፳፻፲፱ መብታዊ
 ምዝገባ ፳፻፲፱ ዓ.ም. ስም ማሻሻልና ማጠናከር ማድረግ

[illegible]

ନିଜାଜ୍ ହାଜିରା ମିଆଁ ଓ ମାଆଜି

לְהַחֲזִיק בְּכָל הַיּוֹם בְּכָל הַלַּיְלָה

୧୩/ ୫ ଟି କଲ୍ୟାଣୀ ୨୦

2020.02.15 04/11/20

ᠠᠨᠠᠨᠪᠠᠭᠠᠳᠤ : www.ulaanbaatar.mn

අංකය: ෧෨෪ - ෧෧ - ෧෩ වන වග

အောက်ဖော်ပြပါအတိုင်း ဂါမဇာ/ ၅၈၅၀၀

୧୩ ପ୍ରସ୍ତାବ ଦିଆଯିବ । ନାମ - ଶ୍ରୀମତୀ ଶ୍ରୀମତୀ ।

ਜ਼ਿਲ੍ਹਾ ਦਫ਼ਤਰ ਲਾਹੌਰ, ੧੯੭੭ - ਅਗਸਤ ੧੯੭੭.



ਅੰਮ੍ਰਿਤਸਰ, ੨੨ ਮਾਰਚ ੧੯੮੨
 ਸ਼੍ਰੀਮਤੀ ਜਸਮੋਹਨੀ ਕੌਰ, ਮਾਮਲਾ ਨੰਬਰ ੧੯੮੨/੧੯੮੩

Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгээс ирүүлсэн “Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хүрээнд хүргүүлж буй тайлбар

Иргэнд эзэмшүүлэх газрын мэдээлэл, газар олголтын талаар

1. Монгол Улсын иргэдээс 2023-2025 онд ирүүлсэн газар эзэмших хүсэлтийн нийт тоон мэдээллийг дүүрэг тус бүрээр, эдгээр хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлыг хугацаанд нь, хугацаа хоцорсон, шийдвэрлээгүй зэргээр ангилан, шалтгаан, шийдвэрлэсэн дундаж хугацааг нийт хүсэлттэй харьцуулсан байдлаар;

Газрын кадастрын мэдээллийн санд 2023 оноос 2025 онд иргэдээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар “Шинээр газар эзэмших” тухай цахим болон цаасан хэлбэрээр нийт 92719 хүсэлт ирүүлсэн байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг дүүргийн Засаг даргын захирамжаар шийдвэрлээд байна.

Үүнээс 2023 онд нийслэлийн хэмжээнд нийт 31631 өргөдөл, хүсэлт ирүүлснээс 26042 хүсэлтийг 202.6 (дундаж хоног) хоногт шийдвэрлэсэн бөгөөд 11381 хүсэлтийг хуулийн хугацаанд, Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө батлагдсаны дараа ирүүлсэн 14661 хүсэлтийг тухайн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлт болон дараа жилийн төлөвлөгөөнд тусгаж Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанаас хоцорч шийдвэрлэсэн, 5589 хүсэлтийг Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байршилд ирүүлсэн тул шийдвэрлээгүй байна.

2024 онд нийслэлийн хэмжээнд нийт 11311 өргөдөл, хүсэлт ирүүлснээс 6365 хүсэлтийг 218.2 (дундаж хоног) хоногт шийдвэрлэсэн бөгөөд 2878 хүсэлтийг хуулийн хугацаанд, Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө батлагдсаны дараа ирүүлсэн 3317 хүсэлтийг тухайн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлт болон дараа жилийн төлөвлөгөөнд тусгаж Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанаас хоцорч шийдвэрлэсэн, 4946 хүсэлтийг Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байршилд ирүүлсэн тул шийдвэрлээгүй байна.

2025 онд нийслэлийн хэмжээнд нийт 49676 өргөдөл, хүсэлт ирүүлснээс 7084 хүсэлтийг 101.2 (дундаж хоног) хоногт шийдвэрлэсэн бөгөөд 2349 хүсэлтийг хуулийн хугацаанд, Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө батлагдсаны дараа ирүүлсэн 4735 хүсэлтийг тухайн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлт болон дараа жилийн төлөвлөгөөнд тусгаж Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанаас хоцорч шийдвэрлэсэн, 42592 хүсэлтийг Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байршилд ирүүлсэн тул шийдвэрлээгүй байна.

Дээрх онуудад шийдвэрлэгдсэн хүсэлтийн дундаж хугацааг нийт хүсэлттэй харьцуулахад 171.3 (дундаж хоног) хоногт шийдвэрлэсэн байна.

Тухайн иргэдийн гаргасан өргөдлийн шийдвэрлэлт удаашралтай байгаа нь дараах шалтгаанаас үүсэж байна. Үүнд:

1. Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4 дэх заалт (хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бүсчлэлд нийцүүлэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах, асуудлыг шийдвэрлэх;), 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг (Хүсэлт гаргасан газрын байршил нь аймаг, сум, нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж болохоор заагдсан байна.), 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт (Хот, тосгон бусад суурины газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн хот, тосгон, бусад суурины харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсрогдож батлагдсан хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу энэ хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ.) тус тус заасны дагуу "Хот, тосгон бусад суурины газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн хот, тосгон, бусад суурины харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсрогдож батлагдсан хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд үндэслэнэ гэж заасан бөгөөд "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г Улсын Их Хуралд өргөн барьсан ба тус төлөвлөгөө батлагдсаны дараа дүүргүүдийн нутаг дэвсгэрт шинээр газар эзэмшүүлэх боломжит байршлуудыг тогтоож, иргэдийн асуудлыг шийдвэрлэх боломжтой байна.

2. Газрын тухай хуулийн 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалт (хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл болон нийслэлийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг дүүрэг бүрээр боловсруулж, дүүргийн Засаг даргын санал, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийн хамт нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх) батлагдсантай холбоотойгоор төлөвлөгөө хийгдээгүй байршилд дээрх хүсэлт гаргасан иргэдийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй байна.

3. Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь (газар дээрх үл хөдлөх хөрөнгө нь тухайн газрын бүрдэл хэсэг байх) заалтын хэрэгжилтийг хангах мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2024 оны 1/1991 дүгээр албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд газрыг кадастрын мэдээллийн санд бүртгэх, газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээ шинэчлэх зэрэг үйл ажиллагаанд хамаарагдаагүй үлдсэн, газар эзэмших эрхийн гэрчилгээгүй, олон жил газар дээрээ суурьшин амьдарсан иргэдийн хүсэлтийг хүлээн авч дүүргийн тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Дээрх шийдвэрийг гаргахдаа Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтад тусгасан үе шатны төлөвлөгөөнүүд батлагдсан байршилд иргэдээс ирүүлсэн хүсэлтийг мөн хуулийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр шинээр газар эзэмшүүлэх, хүчингүй болгох, байршил, хэмжээ, зориулалт өөрчлөх асуудлыг нийслэлийн Засаг дарга нь дүүргийн Засаг даргад бүрэн эрхээ батлагдсан Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тогтоолын хүрээнд шилжүүлж шийдвэрлэсэн байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу газар шинээр эзэмших хүсэлтийг шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд дээрх процессын хүрээнд удаан хугацаанд шийдвэрлэгдэх өргөдлийг тусгай бүртгэлд бүртгэх буюу Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8-д зааснаар дарааллын дагуу эрэмбэлэн бүртгэнэ.

Иймд иргэдээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, үе шатны төлөвлөгөө батлагдсан эсэхийг нягталж, тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн барьж, тухайн оны төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлт болон дараа жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, батлагдсанаар тухайн шатны Засаг дарга шийдвэр гаргах тул холбогдох хууль тогтоомжийн хугацаанд шийдвэрлэх боломжгүй байна.

2. Газрын цахим мэдээллийн систем (egazar.gov.mn)-д газар эзэмшихээр хүсэлт гаргасан дарааллын дагуу иргэдэд тухай бүр хариу өгөх явц, мэдээллийн нээлттэй байдал, системийн хэвийн ажиллагааны талаарх санал, гомдол, шийдвэрлэлтийн байдал

Egazar.gov.mn цахим системээр иргэний гаргасан шинээр газар эзэмших хүсэлтийг Газрын тухай хуулийн 29.8, 29.9 дэх заалтыг үндэслэн үнэ төлбөргүйгээр газар эзэмшихээр цахим системээр гаргасан хүсэлтийг дарааллын дагуу эрэмбэлэн бүртгэж байна.

Мэдээллийн нээлттэй байдлыг хангах хүрээнд иргэн egazar.gov.mn цахим системд ДАН системээр нэвтэрч өөрийн гаргасан хүсэлт аль байршилд, хэд дэх эрэмбэд бүртгэгдсэн, хүсэлтийн шийдвэрлэлтийн явц, төлөв болон шийдвэрийн мэдээллийг цахимаар бодит цаг хугацаанд харах, хянах боломжтой бөгөөд ингэснээр хүсэлтийн дараалал, шийдвэрлэлтийн явц ил тод, нээлттэй байна.

Газрын удирдлагын нэгдсэн цахим систем нь газрын харилцааны бүх бүртгэл, орон зайн өгөгдөл, зураглал болон бусад мэдээллийн санг нэгтгэсэн цогц систем бөгөөд их хэмжээний өгөгдөл, дата мэдээллийг нэг серверийн орчинд боловсруулж байсан нь системийн ачаалал нэмэгдэх шалтгаан болж байсан.

Энэ хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас системийн бүтцийг оновчтой болгож, нэг цогц системийг үйл ажиллагааны чиглэлээр нь 7 дэд систем болгон салгаж, тус тусын серверийн орчинд байршуулан шилжүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд системийн ачаалал

мэдэгдэхүйц буурч, ажиллагааны хурд, тогтвортой байдал сайжирч, хэрэглэгчдэд үзүүлэх цахим үйлчилгээний хүртээмж, найдвартай ажиллагаа нэмэгдсэн.

Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн хэвийн ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг тухай бүр хүлээн авч шийдвэрлэн ажилласан бөгөөд 2023 онд 8, 2024 онд 3, 2025 онд 4 өргөдөл, гомдол ирж шийдвэрлэгдсэн байна. Харин 2026 оны байдлаар Газрын удирдлагын цахим системтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй байна.

3. Нийслэлийн хэмжээнд дуудлага худалдаа, төсөл шалгаруулалт, дараалалд тулгуурласан газар олголтын хувь хэмжээ, үр дүн.

2023-2025 онд газрын биржийн цахим системээр зохион байгуулсан дуудлага худалдаа

№	Он	Зохион байгуулсан тоо	Нийт байршил	Оролцогч	Ялагч тодорсон байршил	Талбай /га/	Орлого /тэрбум, төг/
1	2023	6	66	137	24	27.5	1.3
2	2024	23	125	948	61	117	3.3
3	2025	8	57	215	41	112.8	12.5
	Нийт	37	248	1300	126	257.3	17.1

2023-2025 онд малчдын хоршоодод зориулан зохион байгуулсан төсөл сонгон шалгаруулалт

№	Он	Зохион байгуулсан тоо	Нийт байршил	Оролцогч	Ялагч тодорсон байршил	Талбай /га/
1	2023	-	-	-	-	-
2	2024	1	12	6	6	30
3	2025	1	3	4	3	15
	Нийт	2	15	10	9	45

НИЙСЛЭЛИЙН ИРГЭНД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

4. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан Монгол Улсын иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа газар өмчлөх эрх, Улаанбаатар хотын иргэдийн газар өмчлөх Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангах талаар Монгол Улсын Засгийн газраас баримталж

буй бодлого (Улаанбаатар хотын иргэдээс ирсэн газрын хүсэлтийг шийдвэрлэх тодорхой арга зам, батлагдсан хуваарьт төлөвлөгөө болон хотын иргэдэд зориулж шинээр газар тодорхойлж, нөөц бүрдүүлдэг эсэх, хэрэв нийслэлд өмчлүүлэх газар байхгүй бол Монгол Улсын зөвшөөрөгдсөн бусад нутаг дэвсгэрт хуульд Нийслэлийн иргэнд өмчлүүлэх газрын төлөвлөгөө.

5. Нийслэлийн хэмжээнд иргэнд эзэмшүүлэх, өмчлүүлэх боломжтой газрыг газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөөтэй хэрхэн уялдуулсан талаарх мэдээлэл, газрын кадастрын нарийчлал, давхар бүртгэлийн зөрчлийн тоо, шийдвэрлэлт.

Газрын нөөцийг тодорхойлох:

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022-2036 онд хэрэгжүүлэх Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 95 дугаар тогтоолоор баталсан.

Тус ерөнхий төлөвлөгөөнд нийслэлийн суурьшлын бүсийг цаашид тэлэхгүй байх, хүн амын хэт төвлөрлийг сааруулах бодлогыг баримталж, Багануур, Багахангай дүүрэгт нөөц газар төлөвлөсөн. Мөн нийслэлтэй хил залгаа Төв аймгийн сумдын нутаг дэвсгэрт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон гэр бүлийн хэрэгцээнд ашиглах боломжтой газрын нөөцийг тодорхойлж, дагуул хотуудын хөгжлийг дэмжих замаар нийслэлийн төвлөрлийг бууруулахаар тусгасан.

Нийслэлийн хэмжээнд хот, суурин байгуулахад тохиромжтой газрын нөөц хязгаарлагдмал тул хүн амын төвлөрлийг зөвхөн нийслэлийн нутаг дэвсгэрийн хүрээнд шийдвэрлэх боломж хязгаарлагдмал байна.

Иймд Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан иргэдийг бусад аймаг, сумдад шилжин суурьшихыг дэмжих, урамшуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, нийслэлийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр Засгийн газар болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай байна.

Шинээр газар эзэмшүүлэх:

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4 дэх заалтад “Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бүсчлэлд нийцүүлэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэх”, мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт Хот, тосгон бусад суурины газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн хот, тосгон, бусад суурины харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсрогдож

батлагдсан хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу энэ хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ гэж тус тус заасан.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулахаар Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байгаа бөгөөд уг төлөвлөгөө батлагдсаны дараа түүнд тулгуурласан дүүргүүдийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, гэр бүлийн хэрэгцээнд зориулан шинээр газар эзэмшүүлэх, өмчлүүлэх боломжтой нөөц газрын байршлыг тодорхойлох боломж бүрдэх юм. Улмаар батлагдсан төлөвлөлт болон Засгийн газрын тогтоолоор баталгаажсан байршлуудад Газрын тухай хуульд заасны дагуу газар эзэмших, өмчлөх эрх олгох ажлыг зохион байгуулах боломжтой болно.

Монгол Улсын иргэн шинээр газар эзэмших тухай хүсэлтээ Газрын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу цахим систем болон төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системээр дамжуулан гаргах бөгөөд мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт хүсэлт гаргасан газрын байршил нь тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэхээр заагдсан байх шаардлагатай гэж заасан.

Эдгээр хууль, эрх зүйн зохицуулалтад үндэслэн иргэдийн шинээр газар эзэмших хүсэлтийг бүртгэн, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд шинээр газар эзэмшүүлэхээр тусгагдсан байршилд Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэг болон холбогдох журмын дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

Иймд цахимаар гаргасан хүсэлт нь Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэгдэх хүртэл өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд хадгалагдана гэж тус хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр хуульчилсан.

Мөн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу нийслэлд бүртгэлтэй иргэн нийслэл болон аль ч аймаг, сумын нутаг дэвсгэрт газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэх боломжтой. Иймд улсын хэмжээнд аймаг, сумдын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд шинээр газар эзэмшүүлэх, өмчлүүлэхээр төлөвлөж, баталгаажсан байршлуудад цахимаар гаргасан хүсэлтийг шилжүүлэн шийдвэрлүүлэх боломжтой байна.

Газар өмчлөлийн мэдээлэл

